



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/216

Хэрлэн сум

Үржлийн малд үзлэг ангилалт хийж,
малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох,
ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, 60 дүгээр зүйлийн 60.1.1, 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/136 тоот тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлтэнд хамруулах малын судалгааг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, 2024 оны 06 дугаар сарын -25-ны дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 21-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

**ҮРЖЛИЙН МАЛД ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙЖ, МАЛЫН
ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ,
БҮРТГЭЛТГЭЛЖҮҮЛЭЛТЭНД ХАМРУУЛАХ МАЛ**

№	Сумын нэр	Үүлдэр, омгийн нэр	Ангилалтанд хамруулах малын тоо
1	Галшар	Галшар үүлдрийн адуу	3000
		Галшарын улаан омгийн ямаа	5200
2	Хэрлэн	Тал нутгийн цагаан үүлдрийн хонь	200
3	Дадал	Дадалын ухаа үүлдрийн үхэр	4000
НИЙТ			12400

Тайлбар: ХХААХҮСайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн А/68 тушаалаар батлагдсан “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг тариф”-аар тооцсон болно